## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2023/228-НА-СТА-ТШЗ



| | |
|---|---|
| Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn | Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа |
| | Утас:7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn |
| | Аудитын менежер: Б.Батмөнх |
| Сүхбаатар сум | Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn |
| 2023 он | Ахлах аудитор: Ц.Отгонбаяр |
| | Утас: 7036-3047 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn |



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


1. Аудитын дүгнэлт 3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга 13-16
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 13
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 13-14
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 14
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 14-15
   3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 15-16
4. Аудитын тайлан 17-18
   4.1 Ерөнхий зүйл 17
   4.2 Материаллаг байдал 17
   4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 17-18
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 18
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 18
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 18
5. Аудитын илрүүлэлт 19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл 20


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТНБЦГХЗ | Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа |

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023-02-17 № СТА-2023/228-НА-СТА-ТШЗ

танай ________________-ны № ________________-т

ТУЖИЙН НАРСНЫ БАЙГАЛИЙН
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА Н.ӨЛЗИЙБАЯР
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 92.3 хувьтай тайлагнагдсан бөгөөд цалин хөлс, нэмэгдэл, урамшлын зардлыг 9.9 хувиар, НДШ-ийн зардлыг 12.3 хувиар тус тус хэмнэснээс голлон шалтгаалж нийт төсөв 7.7 хувиар хэмнэгдсэн байна.

018020049

**Аудитын гол асуудал**

Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 81.7 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 12,569.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 11,541.4 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 7,277.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **31,847,795.84** | **27,946,518.59** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 31,847,795.84 | 27,946,518.59 |
| **351** | **Түүхий эд материал** | 3,014,576.59 | 2,618,576.59 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,014,576.59 | 2,618,576.59 |
| 35130 | Эм боох материал | | |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | 870,000.00 | 758,000.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 138,224.25 | 61,907.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 27,824,995.00 | 24,508,035.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 684,320.00 | 319,210.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 6,017,600.00 | 2,135,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,165,000.00 | 50,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 19,958,075.00 | 22,003,825.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **237,230,045.51** | **205,787,606.58** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 237,230,045.51 | 205,787,606.58 |
| **392** | **Биет хөрөнгө** | 193,260,045.55 | 161,867,606.58 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 137,209,013.67 | 137,209,013.67 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -19,226,079.50 | -26,720,101.70 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 90,937,500.00 | 90,937,500.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -36,171,763.79 | -50,118,263.75 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 58,961,308.46 | 58,961,308.46 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -46,132,219.70 | -53,797,272.41 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 11,627,338.43 | 11,627,338.43 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -6,712,603.62 | -8,166,017.43 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 10,740,355.20 | 10,740,355.20 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -7,972,803.60 | -8,806,253.89 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 43,969,999.96 | 43,920,000.00 |
| 39301 | Програм хангамж | 100,000.00 | 100,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -50,000.04 | -100,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 43,920,000.00 | 43,920,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **269,077,841.35** | **233,734,125.17** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **269,077,841.35** | **233,734,125.17** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 269,077,841.35 | 233,734,125.17 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 143,918,285.24 | 143,918,285.24 |
| 51101 | Өмч: - төрийн | 143,918,285.24 | 143,918,285.24 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 50,171,894.87 | 14,828,178.69 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 50,171,894.87 | 50,171,894.87 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -35,343,716.18 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 74,987,661.24 | 74,987,661.24 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **269,077,841.35** | **233,734,125.17** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **314,220,315.00** | **197,965,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **76,198,795.00** | **522,200.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 76,198,795.00 | 522,200.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 584,006.00 | 522,200.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 584,006.00 | 522,200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **238,021,520.00** | **197,443,400.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 227,118,700.00 | 194,777,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 227,118,700.00 | 194,777,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 10,902,820.00 | 2,665,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 10,902,820.00 | 2,665,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **256,545,428.18** | **233,309,316.18** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **256,545,428.18** | **233,309,316.18** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **213,099,131.18** | **217,463,049.18** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 111,232,334.00 | 131,345,901.00 |
| 210101 | Үндсэн цалин | 82,171,994.00 | 100,615,738.00 |
| 210102 | Нэмэгдэл | 25,973,940.00 | 18,324,232.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,086,400.00 | 3,694,900.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 8,711,031.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **14,322,737.00** | **15,822,672.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,258,581.00 | 11,164,411.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,141,724.00 | 1,313,459.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 889,859.00 | 1,050,767.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 184,780.00 | 208,547.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,847,793.00 | 2,085,488.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **8,152,636.00** | **11,541,440.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 600,878.00 | 809,945.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7,039,858.00 | 10,107,057.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 511,900.00 | 624,438.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 10,047,874.61 | 9,319,062.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 577,592.00 | 496,510.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,625,100.00 | 5,113,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,154,300.00 | 1,333,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 93,600.00 | 105,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 725,070.00 | 652,200.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 872,212.61 | 1,618,252.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **3,445,900.00** | **2,475,100.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,445,900.00 | 2,475,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **480,100.00** | **2,001,500.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 30,100.00 | 360,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 450,000.00 | 1,641,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,439,800.00 | 872,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,439,800.00 | 872,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 31,683,122.00 | 12,631,670.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 30,580,502.00 | 11,731,050.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 148,200.00 | 227,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 126,100.00 | 150,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 77,400.00 | 121,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 275,000.00 | 357,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 43,920.00 | 43,920.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,294,627.57 | 31,453,504.18 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,400.00 | 11,065.25 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 32,266,227.57 | 31,442,438.93 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **43,446,297.00** | **15,846,267.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **34,745,700.00** | **700,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 400,000.00 | 700,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 8,700,597.00 | 15,146,267.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **57,674,886.82** | **-35,343,716.18** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **57,674,886.82** | **-35,343,716.18** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **238,605,526.00** | **197,965,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **584,006.00** | **522,200.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 584,006.00 | 522,200.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 584,006.00 | 522,200.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 584,006.00 | 522,200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **238,021,520.00** | **197,443,400.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 227,118,700.00 | 194,777,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 227,118,700.00 | 194,777,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 10,902,820.00 | 2,665,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 10,902,820.00 | 2,665,800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **233,165,926.00** | **197,965,600.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **233,165,926.00** | **197,965,600.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **189,719,629.00** | **182,119,333.00** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 111,232,334.00 | 131,345,901.00 |
| 210101 | Үндсэн цалин | 82,171,994.00 | 100,615,738.00 |
| 210102 | Нэмэгдэл | 25,973,940.00 | 18,324,232.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,086,400.00 | 3,694,900.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 8,711,031.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **14,322,737.00** | **15,822,672.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,258,581.00 | 11,164,411.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,141,724.00 | 1,313,459.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 889,859.00 | 1,050,767.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 184,780.00 | 208,547.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,847,793.00 | 2,085,488.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **8,152,636.00** | **11,541,440.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 600,878.00 | 747,889.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7,039,858.00 | 10,253,539.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 511,900.00 | 540,012.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,816,320.00 | 7,690,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 466,900.00 | 444,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,370,100.00 | 5,113,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,182,500.00 | 1,340,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 93,600.00 | 105,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 703,220.00 | 687,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **5,147,900.00** | **173,100.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,147,900.00 | 173,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **480,100.00** | **2,076,500.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 30,100.00 | 435,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 450,000.00 | 1,641,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,439,800.00 | 872,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,439,800.00 | 872,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 40,127,802.00 | 12,596,820.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 38,875,182.00 | 11,696,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 148,200.00 | 227,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 126,100.00 | 150,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 77,400.00 | 121,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 425,000.00 | 357,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 43,920.00 | 43,920.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **43,446,297.00** | **15,846,267.00** |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 8,700,597.00 | 15,146,267.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 34,745,700.00 | 700,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 400,000.00 | 700,000.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **C01** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **143,918,285.24** | **74,987,661.24** | **(7,502,991.95)** | **211,402,954.53** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 57,674,886.82 | 00.00 |
| **C08** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **143,918,285.24** | **74,987,661.24** | **50,171,894.87** | **269,077,841.35** |
| **D01** | **2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **143,918,285.24** | **74,987,661.24** | **50,171,894.87** | **269,077,841.35** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 143,918,285.24 | 74,987,661.24 | 50,171,894.87 | 269,077,841.35 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -35,343,716.18 | -35,343,716.18 |
| **D09** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **143,918,285.24** | **74,987,661.24** | **14,828,178.69** | **233,734,125.17** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 195,277,600.00 | 180,153,533.00 | 15,124,067.00 | 92.26 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 195,277,600.00 | 180,153,533.00 | 15,124,067.00 | 92.26 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 194,577,600.00 | 179,453,533.00 | 15,124,067.00 | 92.23 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 144,254,300.00 | 131,345,901.00 | 12,908,399.00 | 91.05 |
| 210101 | Үндсэн цалин | 108,160,400.00 | 100,615,738.00 | 7,544,662.00 | 93.02 |
| 210102 | Нэмэгдэл | 24,211,600.00 | 18,324,232.00 | 5,887,368.00 | 75.68 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,737,300.00 | 3,694,900.00 | 42,400.00 | 98.87 |
| 210104 | Урамшуулал | 8,145,000.00 | 8,711,031.00 | -566,031.00 | 106.95 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 18,031,700.00 | 15,822,672.00 | 2,209,028.00 | 87.75 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,261,600.00 | 11,164,411.00 | 1,097,189.00 | 91.05 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,442,500.00 | 1,313,459.00 | 129,041.00 | 91.05 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,154,000.00 | 1,050,767.00 | 103,233.00 | 91.05 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 288,500.00 | 208,547.00 | 79,953.00 | 72.29 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,885,100.00 | 2,085,488.00 | 799,612.00 | 72.28 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,547,200.00 | 11,541,440.00 | 5,760.00 | 99.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 724,300.00 | 747,889.00 | -23,589.00 | 103.26 |
| 210302 | Түлш, халаалт | 10,253,600.00 | 10,253,539.00 | 61.00 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 569,300.00 | 540,012.00 | 29,288.00 | 94.86 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,277,900.00 | 7,277,900.00 | 0.00 | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 444,300.00 | 444,300.00 | 0.00 | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,113,100.00 | 5,113,100.00 | 0.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,340,300.00 | 1,340,300.00 | 0.00 | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 105,800.00 | 105,800.00 | 0.00 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 274,400.00 | 274,400.00 | 0.00 | 100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 173,100.00 | 173,100.00 | 0.00 | 100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 173,100.00 | 173,100.00 | 0.00 | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 135,800.00 | 135,000.00 | 800.00 | 99.41 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 135,800.00 | 135,000.00 | 800.00 | 99.41 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 588,200.00 | 588,200.00 | 0.00 | 100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 588,200.00 | 588,200.00 | 0.00 | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,569,400.00 | 12,569,320.00 | 80.00 | 100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,696,200.00 | 11,696,200.00 | 0.00 | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 227,700.00 | 227,700.00 | 0.00 | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 150,500.00 | 150,500.00 | 0.00 | 100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 121,000.00 | 121,000.00 | 0.00 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 330,000.00 | 330,000.00 | 0.00 | 100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 44,000.00 | 43,920.00 | 80.00 | 99.82 |
| | Бараа үйлчилгээний бусад зардал | | | | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 700000.00 | 700000.00 | 0.00 | 100.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 700,000.00 | 700,000.00 | 0.00 | 100.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 700,000.00 | 700,000.00 | 0.00 | 100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 195,277,600.00 | 180,175,533.00 | 15,101,867.00 | 92.26 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 194,777,600.00 | 179,653,533.00 | 15,124,067.00 | 92.22 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 194,777,600.00 | 179,653,533.00 | 15,124,067.00 | 92.22 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | | 0.00 | |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 500,000.00 | 522,200.00 | -22,200.00 | 104.44 |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 500,000.00 | 522,200.00 | -22,200.00 | 104.44 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 13 | 13 | 0.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 6 | 6 | 0.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3 | 3 | 0.00 | 100.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 3 | 3 | 0.00 | 100.00 |

4317143
МЮА0065 9055436

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,665,800.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,665,800.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,665,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 412,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 412,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,941,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,641,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 284,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 284,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 27,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 27,500.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2665800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,665,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,665,800.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь *"Орхон Сэлэнгийн үзэсгэлэнт сав газар орших "ТУЖИЙН НАРС"-ыг хэвээр хадгалан, тэнд оршин байгаа биологийн төрөл зүйлийн экологийн тэнцвэрт байдал, байгалийн өвөрмөц тогтоц, онцлог төрх нь алдагдах элдэв нөлөөллөөс хамгаалах, байгалийн унаган төрхийг хадгалан хойч үеийнхэндээ өвлүүлэн үлдээх"* гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Нарсан ойг хамгаалах хууль бус ан, мод бэлтгэлийг таслан зогсоох,
- Нарсан ойг нөхөн сэргээх, унаган төрхийг хадгалах,
- Судалгаа шинжилгээний ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр явуулах,
- Иргэдэд сургалт, сурталчилгаа явуулах, экологийн боловсрол олгох,
- Аялал жуулчлалыг зохистой хөгжүүлэх,
- Гадаад, дотоодын хамтын ажиллагааг сайжруулах, хөгжүүлэх.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуулийн 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны санхүүгийн үйл ажиллагаанд БОАЖЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд дотоод хяналт шалгалт, аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4317143923
МҮОА0065 9055436

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/164 дугаар тушаалаар Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35,343.7 мянган төгрөгөөр буюу 13.1 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| **Үзүүлэлт** | **Эхний үлдэгдэл** | **Эцсийн үлдэгдэл** | **Өөрчлөлт** |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Бараа материал | 31,847.80 | 27,946.50 | -3,901.30 |
| Үндсэн хөрөнгө | 237,230.00 | 205,787.60 | -31,442.40 |
| **Нийт хөрөнгө** | **269,077.80** | **233,734.10** | **-35,343.70** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 269,077.80 | 233,734.10 | -35,343.70 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **269,077.80** | **233,734.10** | **-35,343.70** |

Бараа материалын дансны үлдэгдэл 27,946.5 мянган төгрөг болж 3,901.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 18,585.6 мянган төгрөгийн бараа материал худалдан ав сан болон 1,618.3 мянган төгрөгийн бараа материал акталж, 20,868.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө / *анхны өртгөөр* / дансанд өөрчлөлт ороогүй бөгөөд 353,495.5 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 233,734.1 мянган төгрөг болж 35,343.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 286,851.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 89,368.0 мянган төгрөгөөр бууруулж / *бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 46,069.7 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 28,329.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан нь голлон нөлөөлсөн байна.*/ 197,483.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг нийт 2,205.6 мянган төгрөгөөр бууруулж төсвийн зохицуулалт хийсэн байна. Үүнд:

- *Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 5,513.0 мянган төгрөгөөр бууруулж,*
- *Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.*

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 195,277.6 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс 194,777.6 мянган төгрөг, өөрийн орлогоос 500.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр 194,777.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, 522.2 мянган төгрөгийн өөрийн орлого төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 180,153.5 мянган төгрөг буюу 92.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 15,124.1 мянган төгрөгөөр хэмнэж, 22.2 мянган төгрөгийн өөрийн орлогыг улсын төсвийн дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|



4317143998

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 182,881.40 | 167,757.30 | 15,124.10 | 91.73 |
| 2 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 700.00 | 700.00 | 0.00 | 100.00 |
| 3 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 6,307.90 | 6,307.90 | 0.00 | 100.00 |
| 4 | Ургамал хамгаалал | 5,388.30 | 5,388.30 | 0.00 | 100.00 |
| | **Дүн** | **195,277.60** | **180,153.50** | **15,124.10** | **92.26** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130013403 тоот дансанд нийт давсан орлогоос зарцуулах эрх авч 2,665.8 мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна. Үүнд:

- УАЗ маркын автомашины сэлбэгт 1,641.5 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 412.8 мянган төгрөг, компьютерын засварт 327.5 мянган төгрөг, томилолтын зардалд 284.0 мянган төгрөг.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмж өгөгдлөө.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 256,545.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,565.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газрын даргын 2022 оны А-1/856 дугаар "Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээний тухай" албан бичгийг хэрэгжүүлж, төсвийг зохистой удирдаж, авлага, өглөг үүсгэлгүй ажилласан байна.

4317143998
МЮА0065 9035436

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4317143998
МЮА0065 9055436

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар "Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай" албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй болон худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй зэрэг 2 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 2 | 7,540.1 | 2 | 7,540.1 | 100 |
| **Нийт дүн** | **2** | **7,540.1** | **2** | **7,540.1** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,641.5 мянган төгрөгийн зөрчил[1] илэрсэнд зөвлөмж хүргүүллээ.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Анхан шатны баримттай холбоотой асуудал:***

*Илрүүлэлт:* Автомашины засвар үйлчилгээг зайлшгүй хийх шаардлагатай эсэхийг тогтоож, хэлэлцэж шийдвэрлээгүй буюу эвдрэл гэмтлийг нотолсон анхан шатны баримтын бүрдэлгүйгээр албан хэрэгцээнд ашиглаж буй УАЗ маркын автомашины сэлбэг хэрэгслийн зардалд 1,641.5 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*", 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж*: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх .

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаал-тны тоо | Тоо | Дүн |
| Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хийж гүйцэтгэсэн. | 1 | 1,641.5 | | | | | 1 | 1,641.5 | | | | |
| **Дүн** | **1** | **1,641.5** | | | | | **1** | **1,641.5** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |